

**Philosophical foundations of educational development in Mongolia**

Itgel Miyejav

Article information**Article history:**

Received: 2024.11.05

Revised: 2024.11.18

Accepted: 2024.11.20

Keywords:

Vision

Value

Learners' profile

Ethos

Eidos

Praxis

ABSTRACT

There has been growing needs to encourage competing thoughts, debates, cooperation and research works that support critical thoughts, ideas, concepts, approaches, doctrines, and philosophies on development of education in Mongolia.

Nowadays, system inquiry is often regarded as systematic approach for educational development. System inquiry consists of three inter-related components including system theory, system philosophy, and system approach. System philosophy explains the universe from system view and employs system thinking as an approach to theoretical and real life problems.

Itgel and his colleagues (2018, 2023, 2024) published serial articles, which put forward solutions to develop education in system approach. One of the main findings of these articles identified Mongolian education vision, values, learners' profile employing qualitative and quantitative approach. Hence, the current article attempts to give a philosophical explanation to the above-mentioned findings.

We Mongolians place greater emphasis on the beginning and root of anything as we attempt to identify its true meaning and nature. This can be easily observed in our language, culture and way of thinking. As it is traced back to the beginning of philosophy, we can find three concepts namely "ethos, eidos, praxis".

This study identified 47 possibilities for interactions of these three concepts. As it is conceptually mapped, "Mongolian education vision" can be coined as "ethos", "Mongolian education values" can be coined as "eidos" and Mongolian learners' profile can be coined as "praxis" as they are structured to contain one another.

Although Mongolian education vision, values, and learners' profile are identified having their own special characteristics, they are exactly consistent with the topological structure of the global education paradigm.

Finally, the article offers three possibilities to expand the ideas of this study.

Corresponding author:

Itgel Miyejav

Mongolian National Institute for Educational Research

Email: itgel@mier.mn**Монголын боловсролын хөгжлийн философи үндэслэл**

Миеэжавын Итгэл

Санал болгож буй эшлэл:

Итгэл, М. (2024). Монголын боловсролын хөгжлийн философи үндэслэл. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.01>

To cite this article:

Itgel, M. (2024). Philosophical foundations of educational development in Mongolia. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.01>

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ ҮНДЭСЛЭЛ

ОРШИЛ

Орчин үед философи нь аль нэг урсгалаас үл хамааран үнэлэмжийн шинжээ хадгалан салбарлан хөгжих боллоо. Түүний нэг салбар нь “Боловсролын философи” ба энэ нь боловсролын салбарт хуримтлагдсан асуудлууд, тэдгээрийг шийдэх арга замыг эрж хайх нь “Боловсрол” гэх ойлголтын философи үндэслэлийг шаардсан хэрэг юм. Боловсролын ерөнхий дүр төрх, үнэлэмж, боловсролтой хүн зэрэг асуудлуудыг аль ч цаг хугацааны хувьд тавьж болох ч “Боловсролын философи” бие даасан салбар нь 20 дугаар зууны дунд үеэс эхлэн хөгжиж ирснийг Боловсролын хүрээлэнгээс гаргасан бүтээлд тэмдэглэсэн байна (Бэгз ба бусад, 2012).

Манай улсын хувьд 20 дугаар зууны төгсгөл үеэс эхлэн энэ чиглэлд судалгаа хийгдсэн байна. Тухайлбал, ШУА-ийн философийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Монголын философийн номзүй (2015)”-д дараах бүтээлүүд байна. Үүнд: докторын диссертаци Бүжидмаа (2001), Даваадулам (2007), Нэмэхжаргал (2007) ... , нэг сэдэвт бүтээл Чулуундорж (1996), Хавх (1998), Ган-Өлзий (1999), Бүжидмаа (2002), Нэмэхжаргал, Отгонбаяр (2005), Даваадулам (2010), Ичинхорлоо (2011), Бэгз ба бусад (2012), ... болон өгүүлэл Гомбосүрэн (1995, 2011), Дашжамц (1995), Дашпүрэв (1995), Содномдаргиа (1995), Ванчигсүрэн, Энхболд (1998), Хавх (1999), Ганболд (2004), Вандангомбо (2005), Нэмэхжаргал (2005), Цэрэн (2005), Дарьхүү (2009), Ган-Өлзий (2010), Энхбаяр (2010), Дашням (2011), Золзаяа (2011), Отгонбаяр (2011) зэрэг бүтээлүүд байна. Эдгээр бүтээлүүд нь Монголын боловсролын салбарт боловсролын ерөнхий философи болон тодорхой агуулгын хүрээнд хийгдсэн байна.

Тэгвэл сүүлийн үеийн боловсролын философийн бүтээлүүд нь Монголын боловсролд философи гэсэн чиглэлээр хөгжих болжээ. Тухайлбал, Жадамбаа (2020) Монголын боловсролд уламжлал, эрдэм боловсрол, Бадарч (2021) боловсролын парадигмын философи, Бэгз (2023) Монголын боловсролын бодлогын шинэ томъёолол, Цанжид (2023) Монголын боловсролын номлол, Итгэл ба бусад (2023) боловсролын философийн хувьд асуудал (problem) үүсэх, үндсэн ойлголтууд (main concepts), үзэл баримтлалын хүрээ (conceptual framework), үзэл (views), чиг хандлага (paradigm), сонгодог философи (classical philosophy) зэрэг үүсэх гэж хөгжлийн түвшнээр тодорхойлохыг тус тус санал болгосон байна.

Мөн энэхүү салбарыг хөгжүүлэх чиглэлээр 2023 – 2024 онд БСҮХ, МУИС хамтарсан эрдэмтэд, судлаачид болон боловсролын төлөө санаа бодлоо илэрхийлэгчдийн дунд ахмад, дунд, залуу үеийн төлөөллүүд гэсэн гурван удаагийн мэтгэлцээнийг зохион байгуулжээ. Үр дүнгээс нь Боловсролын тухай эргэцүүлэл (2024) судлаач, эрдэмтэн, иргэдийн боловсролын төлөөх санаа бодлыг эмхтгэсэн гарын авлага гарсан байна.

Улмаар 2024 оны 3 дугаар сарын 4 – 5 өдөр БШУЯ, БСҮХ хамтран “Монголын боловсролын хувирган өөрчлөлт” үндэсний чуулганыг олон нийтийн төлөөлөл 800 гаруй оролцогчдыг хамруулан зохион байгуулж, олон талуудын зөвшилцлөөр “Монголын боловсролын тунхаглал 2024” нэрт тунхаг бичиг гаргажээ. Тус бичгийн “Монголын боловсролын философи” гэх нэгэн зүйлд:

- Монголын боловсролын философийг боловсролын даяарчлал, үндэсний онцлогт тулгуурлан хөгжүүлнэ.
- Монголын боловсролын философи нь Монгол Улсын боловсролын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах нэг үндэслэл болно.
- Монголын боловсролын философи нь судлаач, эрдэмтэн, багш, иргэн бүрийн үзэл бодлоо илэрхийлэх академик эрх чөлөөний талбар байна гэжээ.

Тухайлбал, Монголын боловсрол зөвхөн даяарчлалын хандлагатай хөгжинө, эсвэл зөвхөн уламжлал дээр тулгуурлан хөгжинө, эсвэл үндэсний үзэл тэргүүн зэрэгт байна гэх мэт олон ургальч үзэл бодлуудын хариуд “Монголын боловсролын философийг боловсролын даяарчлал, үндэсний онцлогт тулгуурлан хөгжүүлнэ” гэх шийдлийн хувилбар дэвшүүлжээ. Түүнчлэн, НҮБ (2022)-ын “боловсролын хувирган өөрчлөлт (transforming education)”-ийн үзэл санаа буюу бид боловсролоо хөгжүүлэхдээ:

- Байгаа зүйлийнхээ юуг нь цааш үргэлжлүүлэх вэ?
- Байгаа зүйлийн юуг нь үлдээх вэ?

- Юуг шинээр бүтээж, цааш хөгжүүлэх вэ?

гэсэн асуултад хариулах нь даяарчлалын хандлагад харьяалагдах үзэл санаа гэж ойлгогдож байна.

Бид цаашид Монголын боловсролыг хөгжүүлэх бодол, санал, үзэл санаа, үзэл баримтлал, хандлага, номлол, философийг илэрхийлэх, тайлбарлахад оюун бодлоо уралдуулан хэлэлцэх, мэтгэлцэх, хамтрах, улмаар тодорхой судалгааны бүтээлүүд гаргах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

ҮНДСЭН АГУУЛГА

Орчин үед боловсролыг хөгжүүлэх системийн хандлага нь боловсролын парадигмыг тайлбарлах нэг арга зам буюу “системийн судалгаа (systems inquiry)” юм.

Системийн судалгаа нь системийн онол, системийн философи, системийн арга зүй гэсэн хоорондоо хамаарал бүхий гурван хэсгээс тогтоно. Системийн философи нь ертөнцийг системчилсэн үзэл (systems view), системийн сэтгэхүйг онолын болон бодит ертөнцийн асуудалд хандах хандлага болгон тайлбарлахад оршино (Bertalanffy, 1968). Системийн үзэл (systems view) нь бидний сонирхож буй систем, түүний орчин, түүний бүрэлдэхүүн хэсэг, хэсгүүдийг судлах, тодорхойлох боломжийг бидэнд олгодог (Бадарч & Мөнххүж, 2014). Мөн системийн үзэл, зарчмуудын тусламжтайгаар сэтгэхүйн үйл ажиллагаа өрнүүлэн боловсролыг шинэ өнцгөөр харж, шинэ аргаар бодох, боломжит технологи ашиглан судлах, ойлгох, дүрслэх бололцоог бүрдүүлж өгдөг (Banathy & Jenlink, 2004). Боловсрол нь олон талтай, өргөн хүрээтэй, нийлмэл бүтэцтэй үйл явц бүхий нийгмийн эдийн засаг, улс төр, материаллаг хангамжийн түвшнийг тодорхойлдог, харьцангуй бие даасан систем юм (Бэгз, 2008, х.10). Энэ утгаараа боловсролыг танин мэдэхүйн ерөнхийгөөс тусгайд шилжих чиглэлийн дагуу системийн судалгаа хийх боломжтой юм. Өнөөгийн байдлаар боловсролыг системийн үзлээр судлах чиглэлээр англи хэлээр Argyus (1982), Banathy (1991), Jackson (1991), Jenlink (2001), Midgley (2000), Nelson (1993), Senge (1990), Southerland (1973), Reigeluth (1993), орос хэлээр Архангельский (1980), Беспалько (1990), Камалева (2015), Кузьмина (2002), Остапенко (2013), монгол хэлээр Бадарч (2019), Бэгз (2017), Итгэл (2018), Пүрэвдорж (2002), Энхтүвшин (2014) нарын бүтээл байна.

Боловсролыг системийн хандлагаар хөгжүүлэх шийдэл дэвшүүлсэн Итгэл ба бусад (2018, 2023, 2024)-ийн цуврал өгүүлүүд байна. Эдгээр ажлын гол үр дүнгийн нэг нь чанарын болон тоон судалгаагаар Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрхийг тодорхойлсон байна.


Монголын боловсролыг хувирган өөрчлөх үйл явцын инновац хийх үйл явц гэж ойлгож болно. Тэгвэл судлаач Berglund (2007, х. 54) судалгааг инновацийн үйл явц байдлаар зохион байгуулж болно. Энэ нь процессын хувьд төвөгтэй боловч инновацийн хүрээг 5 түвшинтэйгээр тодорхойлсон ба эхний үе шатыг “санаа төрөх” гэжээ. Энэ утгаараа, Монголын боловсролыг хөгжүүлэх санаа хэрхэн төрсөн бэ? гэдэгт хариулах хэрэг гарна.

Тэгвэл Монголын боловсролын хөгжүүлэх гол санааг дараах байдлаар олсон юм. Системийн хандлага ба үндэсний сэтгэлгээний онцлогийг шингээн хөгжүүлэх талаар БСҮХ дээр хэлэлцүүлэг өрнүүлж дараах санаа гарсан юм.

Д.Нацагдоржийн Дөрвөн цаг шүлгийн санаанаас эхний санааг гаргав. Ингэхдээ даяарчлалын хувьд VUCA, OECD-ийн боловсролын үнэт зүйлийн ангилал, хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ийн Transforming Education уриалгыг хүлээн зөвшөөрч, дангаарчлалын хувьд Үндсэн хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хувьсаж буй боловсрол хэлэлцүүлгийн үр дүнг тооцсон болно.


Харин:

- Боловсрол нь ямар том системийн дэд хэсэг вэ? гэдэг нь Экосистем
- Тус экосистемээс Боловсролын Чиглэх алтан гадас нь Алсын хараа
- Алсын хараа руу хөтлөх луужин нь Үнэт зүйл
- Нийгэмд төлөвших хүн нь Монгол суралцагч байна гэсэн ерөнхий санааг тус шүлгийн дөрвөн улирлыг төлөөлүүлэн зураглав (Зураг 1).



Зураг 1. Монголын боловсролыг хөгжүүлэх санаа

Тус санааг хөгжүүлэн Зураг 2-т үзүүлсэн үр дүнг илрүүлэв (Итгэл ба бусад, 2024).



Зураг 2. Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрхийн холбоо

Тэгвэл энэ үр дүнгийн философи тайлбарыг өгөх нь бидний судалгааны зорилго юм.

Илтгэлийн санаа

Монголчууд аливаа зүйлийн утга учир, мөн чанарыг танин барихдаа түүний эх үндэс буюу эхлэлийн цэгт ихээхэн анхаарал хандуулдаг нь хэл, соёл, сэтгэлгээнд нь гүн шингэжээ. Тухайлбал, Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа, санаа зөв бол заяа зөв, эх нь булингартай бол адаг нь булингартай (Эрдэнэ-Очир, 1983) зүйр цэцэн үгэнд дедуктив логик (Батгөмөр, 2005, х.172), логик квадрат (Отгонбаяр, 2016) байна.

Мөн булаг шандны эхийг хамгаалах ёс, заншил, гэр бүл болоход найрын дэг жаягт сайн сайхны ерөөл зэрэг нь соёлд шингэжээ. Бэлэг дэмбэрэлт болон энгийнээс аугаад шилжих (Цанжид, 2022, х.61) хэв маяг

сэтгэлгээнд нь байдаг ажээ.

Монгол хэлэнд тухайн зүйлийн одоогоос эх рүү тэмүүлэх хандлага нь үлгэр, домгийн сэтгэлгээнд ч мөн үлджээ. Тухайлбал,

Сүн далайг шалбааг байхад,

Сүмбэр уулыг дов байхад ... хэмээн ертөнцийн юмс үзэгдэл, орчлон дэлхийн түмэн бодисын ухааныг үлгэр домгийн сэтгэлгээгээр дамжуулж монгол хүүхдийн хүртэхүй, мэдрэмжид таниулж иржээ. Монгол соёлд тодруулбал, уртын дуу “Эртний сайхан” нь монгол үндэстний бүх зүйлийн эхлэл сайн сайхан байхаас улбаалан ирээдүй үе маань мөн сайн сайхан байх утга агуулгатай юм.

Тэгвэл философийн эх үндэс рүү тэмүүлсэн судалгаа буюу эртний суут эрдэмтдийн сургаалыг харвал яахын аргагүй “ethos, eidos, praxis” гэсэн ойлголтууд гарна. Энэ гурвал нь грек үг ба Платон, Аристотель зэрэг философичид анхлан хөгжүүлжээ. Профессор Бадарч Боловсролын парадигм гэдгийг энэ гурван ойлголтоор тайлбарласан байна (2021, х.13–15.).

Ethos – улс үндэстэн, нийгмийг илэрхийлэх итгэл үнэмшил (ёс зүй) гэсэн утгатай. Энэ нь тухайн зүйлийн алсын хараа, баримталж буй философийг,

Eidos – шинэ санаа, хэлбэрийн тухай онол ба Платон хэлбэрийн онолоо ингэж нэрлэсэн байна. Энэ нь тухайн зүйлийн үнэт зүйл, шинэ санааны үүднээс тодорхойлсон хүрэх ирээдүйн дүр төрхийг,

Praxis – онол, сургаалыг хэрэгжүүлэх үйл явц гэсэн утгатай гэж тодорхойлжээ. Энэ нь ирээдүйн дүр төрхийг хэрэгжүүлэх системийн дизайн юм. Тэгвэл тогтвортой хөгжлийн судлаач Stirling (2003) дараах байдлаар тайлбарлажээ.

Ethos – итгэл үнэмшил, үйл ажиллагааны чиглэлийг баталгаажуулдаг сэтгэл хөдлөл, төсөөллийн хэмжигдэхүүн,

Eidos – бидний ертөнцийг хэрхэн төсөөлдөг тухай санаа болон үзэл баримтлалын хэмжээс,

Praxis – үйл ажиллагааг илэрхийлэх хэмжигдэхүүн,

Энэхүү гурвал нь парадигмын өөрчлөлтийг дэмжих боломжтой системийн сэтгэлгээний үзэл баримтлалыг бүрдүүлэх ба гурвалыг хэрхэн хөгжүүлэхээс парадигмын боломж нь хамаарна (Bosevska, Kriewaldt, 2019) гээд эдгээр нь дараах боломжийг олгодог гэжээ. Үүнд:














Ethos – Алсын хараа (vision): философи ба чиглэл,

Eidos – Ирээдүйн дүр төрх (image): үндсэн үнэт зүйлс, үзэл баримтлалын хувьд хүссэн төлөвийн тухай үндэслэл,

Praxis – Дизайн (design): энэ нь ирээдүйн дүр төрхийг хэрэгжүүлэх.

Тэгвэл боловсролын парадигм нь энэ гурван ойлголтыг хэрхэн авч үзэхээс хамаарна. Тодруулбал, гурван ойлголтын харилцаанаас түүнд хандах философийн үзэл санаанууд урган гарна. Тэгвэл эдгээр гурван ойлголтын хамаарлыг логик хэл - олонлог дүрслэл болон математикийн аппарат - комбинаторикийн тооцооллоор бодож 47 боломжийг илрүүлж болж байна (магадгүй бүрэн биш байх талтай).

Хүснэгт 1. Гурван ойлголтын хамаарлын (топологи) бүтэц

Төрөл	I	II	III	IV	V	VI
Олонлог						
Боломжийн тоо	1	3	1	6	6	6
VII	VIII	IX	X	XI	XII	XIII
						
3	6	3	3	3	3	3

гэсэн ... боломж байна.

Эдгээрээс манай философи нь аль боломж вэ? гэдгийг тодруулбал, Монгол Улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааны бүрдэл хэсэг нь

- *Ethos* - Монголын боловсролын алсын хараа
- *Eidos* – Монголын боловсролын үнэт зүйл
- *Praxis* - Монгол суралцагчийн дүр төрх

болно (Итгэл ба бусад, 2024).

Учир нь Монголын боловсролын хувирган өөрчлөлтийн шийдэл нь боловсрол ба экосистем, бүтцийн, динамик гэсэн гурван загварт (Итгэл ба бусад, 2023) тулгуурласан байна. Үүнд:

1. Боловсрол ба экосистемийн загвараас:

- Монголын боловсролын экосистемийн ангиллыг тодорхойлох,
- Экосистемийн ангилал бүрд алсын харааг тогтоох,
- Алсын хараа бүрд чиглэсэн үнэт зүйлийг илрүүлэх,
- Үнэт зүйл дээр суурилан суралцагчийн дүр төрхийг гаргах,

2. Боловсролын бүтцийн загвараас:


- Монголын боловсролын бүтэц буюу бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох,
- Тус бүтэц нь суралцагч төвтэй байх,
- Тус загвараас тэргүүлэх чиглэлийг тогтоох,

3. Боловсролын динамик загвараас:

- Бүтцийн загварын бүрэлдэхүүн бүрийг хугацааны хувьд эрэмбэлэн байрлуулах,
- Динамик загвараас зарим бүрэлдэхүүн хэсгийн агуулгыг илрүүлэх,

гэсэн шийдэл олдоно.

Иймд алсын хараа бүрд үнэт зүйл, үнэт зүйл бүрд суралцагчийн дүр төрх гарсан нь олонлогийн хэлээр бол нэг нэгэндээ агуулагдана (Зураг 3). Иймд энэ нь V төрлийн *ethos, eidos, praxis* гэснийг агуулсан байна.



Зураг 3. Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрхийн хамаарал

Мөн боловсролын алсын харааг бүх нийтийн сайн сайхан байдлын төлөө гэж үзэн суралцагчийн дүр төрх, ирээдүйд эзэмших чадамжийг тодорхойлон, эдгээрт үндэслэн үйл ажиллагаагаа зохион байгуулж


буй олон улсын нэр хүндтэй байгууллагууд цөөнгүй байна. Тухайлбал, суралцахуйн хүрээ 2030 (OECD, 2019), боловсролын нийгмийн шинэ гэрээ (UNESCO, 2021), боловсролын хувирган өөрчлөлт (UN, 2022) боловсрол 4.0 (WEF, 2023) зэрэг үзэл санаанууд нь мөн V төрлийн загвартай байна.

Судлаач Sterling (2003) тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тайлбарласан байна.

Хүснэгт 2. Тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн

Ethos	Эпистимологи	Боловсролын парадигмын зорилго	Үндсэн үнэт зүйлс; Тогтвортой байдлын шилжилтийн бүх хэмжигдэхүүнд оролцох (нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэх мэт); байх / болох
Eidos	Онтологи	Боловсролын бодлого, онол, загвар	Хичээлийн хөтөлбөр дизайн; олон нийтийн холбоосууд; далд сургалтын хөтөлбөр; үнэлгээ / үнэлгээ
Praxis	Методологи	Сурган хүмүүжүүлэх ухаан, суралцахуй, практик үйл ажиллагаа	Суралцагч болон суралцахуйн талаарх бүхэл системийн үзэл; сургалтын хэв маяг; оролцоотой суралцахуй

Мөн Bosevska, Kriewaldt (2019) нар тогтвортой боловсролын онолын үндэслэлийг дүрсэлжээ (Зураг 4). Энд систем байхын тулд Ethos, систем сэтгэдэг байхын тулд Eidos, систем амьд байхын тулд praxis байна гэсэн санаан дээр, зүрх, тархи, гар гэсэн бүхэл системийн ойлголтуудыг нэгтгэн дүрсэлжээ.



Зураг 4. Тогтвортой боловсролын онолын үндэслэл

Энэ нь бидний Монголын боловсролын хөгжлийн философиыг тодорхойлох үзэл санаатай нийцэж байна.

Цаашид хөгжүүлж болох нэгэн боломж. Мөн бидний энэ V төрлийн ethos, eidos, praxis гэсэн загварыг практик байдлаар цааш нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх боломж байна. Тухайлбал,

- ethos - Монгол суралцагчийн дүр төрх, eidos - бүтцийн загвар, praxis - динамик загвар,
- ethos - динамик загвар, eidos - сургалтын хөтөлбөр, praxis - сургалтын хөтөлбөр боловсруулалт,
- ethos - сургалтын хөтөлбөр боловсруулалт, eidos - сургалтын хөтөлбөрийн дизайн, praxis - бүтээгдэхүүн,
- ethos - бүтээгдэхүүн, eidos - сурах бичгийн стандарт, praxis - сурагчийн дасгал ажлын дэвтэр

гэх мэтээр хөгжүүлэлт хийх боломжтой байна.

Цаашид хөгжүүлж болох нэгэн боломж. Парадигмыг тайлбарлах ethos, eidos, praxis ойлголтын 47 боломж бүрийн хувьд орц, явц, гарц гэсэн загвараар хандан ямар зүйлийг орц дээр өгөхөд, ямар гарц гарах вэ? эсвэл ямар гарц гаргаж авахын тулд ямар орц зайлшгүй хэрэгтэй вэ? ямар үйл явц хэрэгтэй вэ? зэрэг кибернетикийн бодлогоор хөгжүүлж болно гэж үзэж байна.

Цаашид хөгжүүлж болох нэгэн боломж. Боловсролын парадигм нь өнөөдөр V төрлийн ethos, eidos, praxis гэсэн бүтэцтэй байна. Үүнийг бид, өнөөдрийн нийгэм эрчимтэй хөгжиж улам нарийн төвөгтэй нөхцөл байдал үүсэж VUCA (volatility, uncertainty, complexity, ambiguity) буюу тогтворгүй, тодорхойгүй, ээдрээтэй, олон санаа агуулсан байдал гэж үзэж ийм нөхцөлд ирээдүйгээ төсөөлөх, таамаглахын аргагүй болж байгаа нөхцөлд тэргүүн ээлжид бүх нийтийн сайн сайхан байдал гэж үзэж байна. Энэ нь бидний үйлдлийн үр дагаврыг сайн сайхан байдлаар хэмжих нь найдвартай, тохирцтой, алдаа мадаг багатай гэсэн үзэл юм. Харин ирээдүйн чиг хандлагын хувьд eidos нь бусад хоёр ойлголтоо агуулсан шинжтэйгээр хөгжүүлэх боломжтой гэж таамаглаж байна. Энэ нь eidos буюу санаа анхдагч гэсэн үзлээр хөгжүүлнэ гэсэн үг бөгөөд ухамсар анхдагч гэсэн үзэлтэй ижил байж болох юм. Учир нь оюун ухаан нь сэтгэл зүрхээ удирдана гэсэн загвар юм. Иймд бид “саруул ухаан”-аар удирдах нь “сэтгэл зүрх”-ээр удирдсанаас илүү гэж таамаглаж байна. Энэ нь V, VII, IX төрлөөр хөгжиж боломжтой.

ДҮГНЭЛТ

Монголын боловсролын хөгжлийн парадигмын тайлбарлалт нь боловсролын олон улсын хандлагын парадигмын бүтцүүд нь ижил байна (V загвар). Иймд бидний боловсролыг хөгжүүлэх философи үзэл нь олон улсын хандлагатай нийцэж байна гэж үзэж болохоор байна. Тодруулбал, Монголын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрх, динамик загварууд нь бусдаас ялгарах онцлогтой тодорхойлогдсон ч топологи бүтцийн хувьд ижил гэсэн үг юм. Энэ нь Монголын боловсролын тунхаглалд “Монголын боловсролын философийг боловсролын даяарчлал, үндэсний онцлогт тулгуурлан хөгжүүлнэ” хэмээсэнтэй нийцэж байна гэж дүгнэв.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

- Бадарч, Д., Мөнххүж, Б. (2014). Системийн сэтгэлгээ, Улаанбаатар: ШУТИС хэвлэх үйлдвэр.
- Бадарч, Д. (2021). *Дээд боловсролын онол, арга зүй (Парадигмын шижилт, багшлахуй, суралцахуй) Дэд дэвтэр*. Улаанбаатар: ШУТИС-ийн хэвлэх газар.
- Баттөмөр, Д. (2005). *Логик, эпистимологи, шинжлэх ухааны философийн асуудлууд*. Улаанбаатар.
- БСҮХ, МУИС. (2024). *Боловсролын философийн тухай эргэцүүлэл. (Монголын боловсролын философи цуврал №2)*. Улаанбаатар.
- Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бэгз, Н., Пүрэв, О., Энхцогт, Н., Багтогтох, Д., Баярцэцэг, Б., Мягмар, П., Лхагвасүрэн, Ц., Тунгалаг, П. (2012). *Боловсролын философи. (Эрхлэн гаргасан байгууллага: Боловсролын хүрээлэн)* Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бэгз, Н. (2023). *Монголын боловсрол судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Туяа, У., Эрдэнэ, Л., & Пунцагсүрэн, Д. (2023). Боловсролыг системийн үзлээр хөгжүүлэх шийдлүүд. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 28 (1). <https://doi.org/10.56380/mjer.v28.1.2>
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролын тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.1>
- Отгонбаяр, М. (2016). *Логик*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Философийн хүрээлэн. (2015). *Монголын философийн номзүй (Эмхт. Золзаяа, Жигмэддорж)*. Улаанбаатар.
- Цанжид, А. (2022). *Уугуул Монгол соёл*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Эрдэнэ-Очир, Г. (1983). *Зарим зүйр цэцэн үгийн тайлбар толь*. Улаанбаатар: Ардын боловсролын яамны хэвлэл.

Англи хэлээр:

- Banathy, B. H., Jenlink, P. M. (2004). Systems inquiry and its application in education. In D. H. E. Jonassen (Ed.), *Handbook of research for educational communications and technology* (2nd ed., pp. 37-58). Mahwah, NJ: Lawrence Erlbaum Associates.
- Bertalanffy, L. (1968). *General systems theory*. New York: Braziller.

- Bosevska, J. Kriewaldt, J. (2019). Fostering a whole-school approach to sustainability: learning from one school's journey towards sustainable education. *International Research in Geographical and Environmental Education*, 29(1), 55–73. <https://doi.org/10.1080/10382046.2019.1661127>
- OECD. (2019). Future of Education and Skills 2030. Conceptual learning framework. Skills for 2030. Татаж авсан холбоос <https://www.oecd.org/en/about/projects/future-of-education-and-skills-2030.html>
- Sterling, S. (2003). *Whole systems thinking as a basis for paradigm change in education: Explorations in the context of sustainability* (PhD Dissertation). University of Bath.
- UN. (2023). *Report on the 2022 Transforming Education Summit*.
- UNESCO. (2021). Reimagining our futures together: a new social contract for education. Paris, 186 pages, ISBN 978-92-3-100478-0. Татаж авсан холбоос [Reimagining our futures together: a new social contract for education;executive summary - UNESCO Digital Library](#)
- WEF. (2023). *Defining Education 4.0: A Taxonomy for the Future of Learning*. https://www3.weforum.org/docs/WEF_Defining_Education_4.0_2023.pdf